



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024, 07.01 № 860
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ БИЕ
ДААН НЭР ДЭВШИГЧДЭД

Мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д "...бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх"-ийг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хянаж, дүгнэлт гаргахаар заасан.

Энэхүү зохицуулалтын дагуу сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт аудит хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

1.Аудитыг Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн хүрээнд MNS 6817:2020-Төрийн аудитын стандартын дагуу гүйцэтгэх ба дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1.1 Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан мөрийн хөтөлбөрт тусгахыг хориглосон заалт байгаа эсэхийг хянах;
- 1.2 Мөрийн хөтөлбөр нь хуульд заасан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Улсын Их хурлаас баталсан хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт нийцсэн эсэхийг хянах;
- 1.3 Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт, арга хэмжээ нь хуульд заасан Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичигт нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд гарах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэхийг хянах;
- 1.4 Тодруулах зүйлсийг тухай бүр мэдэгдэх бөгөөд аудитын явцад удирдлагаас нэмэлт мэдээлэл, тайлбар авах;
- 1.5 Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.9-д заасны дагуу сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлага

002022033

хангаагүй дүгнэлт гарсан тохиолдолд тав хоногийн дотор зөрчлийг арилгуулж, дахин дүгнэлт гаргах зэрэг болно.

2. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн дагуу бие даан нэр дэвшигч нь дараах үүрэг хариуцлагыг хүлээж байна. Үүнд:

2.1 Бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртөө дүгнэлт гаргуулахаар 07 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн байх /Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.6/;

2.2 Бие даан нэр дэвшигч нь сонгуульд оролцох хүсэлтийг санал авах өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө илэрхийлэхдээ дээрх дүгнэлтийг гаргуулсан байх /Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, мөн зүйлийн 31.3.9/;

2.3 Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр болон түүнд дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл /энэхүү захидлын нэг ба хоёрдугаар хавсралт/ мөн мөрийн хөтөлбөрийн 3 эх хувийг хэвлэмэл байдлаар, хувийг /файл хэлбэрээр/ дугтуйнд хийж битүүмжлэлтэйгээр /Нийслэл дэх Төрийн аудитын газар Соёлын төв өргөө Г корпус 4 давхар 424 тоот/ -т ажлын цагаар хүлээлгэн өгнө. Дугтуйн дээр бие даан нэр дэвшигчийн нэрийг гаргацтайгаар бичсэн байна.

Аудит гүйцэтгэх хугацаанд сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих мөрийн хөтөлбөрийг шаардлагатай баримт, материалын хамт ирүүлэх, аудитын зорилгоор хүссэн нэмэлт тайлбар, мэдээллийг бичгээр баталгаажуулж өгөх, аудитын бусад нотолгоог олж авах нөхцөл, боломжоор хангаж ажиллана уу.

Бие даан нэр дэвшигч нь хуулийн дээрх зохицуулалтуудыг анхаарч мөрийн хөтөлбөрөө хуулийн хугацаанд ирүүлэх бөгөөд тус чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор тухайн бие даан нэр дэвшигчийг төлөөлөн шууд харилцах иргэний мэдээлэл, нотлох баримт, итгэмжлэл, бие даан нэр дэвшигчийн иргэний үнэмлэхийн хуулбарын хамт ирүүлж, иргэн солигдох, өөрчлөгдөх бүрд нийслэл дэх Төрийн аудитын газарт мэдэгдэж ажиллахыг хүсье.

Аудитыг хуулиар тогтоосон хугацаанд гүйцэтгэхэд харилцан хүлээсэн үүргээ хэрэгжүүлж хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

Хавсралт: 2. . хуудастай.


Мэдээлэл ирүүлэх цахим хаяг: Lkhagvasuren@audit.gov.mn

Хүндэтгэсэн.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ




Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.3, 5.4-т заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан ..., бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн хавсралтаар ирүүлэх мэдээлэл

№	Нам, эвслийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн тооцооллыг хийхдээ төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг баримталсан эсэх (тийм, үгүй)	Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийн нэр, холбогдох заалтыг бичих	Тайлбар
	А	1	2	3
1				
2				
...				

Жич:

- 2 дугаар баганад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцоолохдоо төсвийн төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг баримталсан эсэх
- 3 дугаар баганад Монгол Улсын хөгжлийн бодлогын ямар баримт бичгийн аль заалтыг үндэслэл болгосныг тодорхой бичнэ.

Мэдээллийг бэлтгэсэн.....-ыг төлөөлж
Нам/эвслийн/нэр
(тэмдэг)..... ийг төлөөлж
албан тушаал овог нэр гарын үсэг
(тэмдэг)..... ийг төлөөлж
албан тушаал овог нэр гарын үсэг
2024 оны ... сарын ... өдөр



Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2024 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 60 дугаар албан бичгийн хоёрдугаар хавсралт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан дүгнэлт гаргахтай холбогдуулан ..., бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн хавсралтаар ирүүлэх мэдээлэл

№	Нам, эвслийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан санхүүгийн эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээ	Хамрах хугацаа	Шаардагдах санхүүгийн эх үүсвэр (Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 20.2.1-20.2.6 дахь заалт)	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн нийт дүн	Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн хэмжээ төсвийн жил тус бүрээр				Тайлбар
					202...	202...	202...	202...	
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Жишээ: "Төсвийн дэмжлэгтэй бүтээн босголт, хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээний нэр"	Жишээ: 2024-2028	Жишээ: 20.2.1. улсын төсөв; 20.2.2. гадаадын зээл; 20.2.5. төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ;	Жишээ: 1'626.2	Жишээ: 406.6	Жишээ: 406.6	Жишээ: 406.6	Жишээ: 406.6	Жишээ: Санхүүжилтийг 4 жилд тэнцүү зарцуулахаар төлөвлөв.
2									
...									
	Бүгд дүн								

Жич:

- 3 дугаар баганад шаардагдах санхүүгийн эх үүсвэр нь ХБТТУХ-ийн 20.2.6 дахь заалтад хамаарна гэж мэдээлсэн тохиолдолд энэ ангилалд хамааруулах үндэслэл, тайлбар, нотлох зүйлийн хамт ирүүлнэ.

Мэдээллийг бэлтгэсэн.....-ыг төлөөлж
Нам/эвслийн/нэр
(тэмдэг)..... ийг төлөөлж
албан тушаал овог нэр гарын үсэг
(тэмдэг)..... ийг төлөөлж
албан тушаал овог нэр гарын үсэг
2024 оны ... сарын ... өдөр